

Хүүхэд асран хүмүүжүүлж буй бага орлоготой өрхөд олгох амьжиргааг дэмжих тусгай тэтгэмжийн тухай (Өрх толгойлсон эцэг, эх)

Өрх толгойлсон ганц бие эцэг, эхийг дэмжих зорилгоор шинэ тэтгэмжийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо!

1. Тэтгэмжид хамрагдах иргэд

■ Доорх ①-③-ын аль нэгт хамрагдах иргэн

- ① 2022 оны 4-р сарын хүүхэд асарсны тэтгэмж олгогдсон
- ② Нийгмийн халамж, тэтгэвэр авч байгаа учраас 2022 оны 4-р сарын хүүхэд асарсны тэтгэмж олгогдоогүй
(“Нийгмийн халамж, тэтгэвэр” гэдэгт өвлөж авсан тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргийн, өндөр насны, хөдөлмөрийн ослын тэтгэмжүүд ба тэжээгчээ алдсаны нөхөн олговор зэрэг багтана.)
- ③ Шинэ корона вирусын халдварт өвчний нөлөөгөөр **өрхийн орлого нь хүүхдийн тэтгэмж авдаг хүнтэй ижил түвшинд буурсан иргэн**

2. Тэтгэмжийн мөнгөн дүн

Нэг хүүхдэд **50,000 иен**

■ Тэтгэмжид хамрагдах заавар арын хуудсанд байгаа тул сайтар шалгана уу.

* Мөн, доорх утсаар холбогдож лавлана уу.

■ Нийгмийн халамж, хөдөлмөрийн яамны лавлагаа мэдээллийн төв

0120-400-903 (Ажлын өдрүүдэд 09.00-18.00)

○ Хүсэлт гаргах дэлгэрэнгүй мэдээллийг оршин суугаа харья захиргааны “Хүүхэд асран хүмүүжүүлж буй өрхөд олгох амьжиргааг дэмжих тусгай тэтгэмж” (Өрх толгойлсон эцэг, эх)-ийг хариуцах цонхон дээрээс авна уу.

3. Тэтгэмж авах хүсэлт гаргах

■ 2022 оны 4-р сарын хүүхэд асарсны тэтгэмж олгогдсон иргэн (Эхний нүүрийн ①-т хамрагдах иргэн)


- ▶ Уг тэтгэмжийг авахад **хүсэлт гаргах шаардлагагүй**.
- ▶ 6-р сарын үеээр 2022 оны 4-р сарын хүүхэд асарсны тэтгэмж олгогдсон дансанд орно.

【Анхаарах зүйлс】

- * Тэтгэмж шаардлагагүй бол танд явуулах тэтгэмжээс татгалзах хүсэлтийн хуудсыг бөглөн буцааж явуулна уу.
- * Хүүхэд асарсны тэтгэмж хүлээн авдаг данс нь хаагдсан зэрэг тэтгэмж олголт саатах эрсдэлтэй бол дансны мэдээллээ шинэчилж мэдүүлнэ үү.

■ Дээрхээс бусад иргэд (Эхний нүүрийн ② эсвэл ③-ны аль нэгт хамрагдах иргэн)

- ▶ Уг тэтгэмжийг авахад **хүсэлт гаргах шаардлагатай**
- ▶ Хүсэлтийн хуудаст дансны дугаар зэрэг мэдээлэл оруулж, шаардлагатай бичиг баримтийг хавсарган оршин суугаа газрын захиргааны цонхонд **шууд өгөх** буюу **шуудангаар** явуулна уу.
- ▶ Тэтгэмж авах нөхцөл хангагдсан бол хүсэлтийг шалгасны дараа заагдсан дансанд **аль болох шуурхай** шилжүүлэх болно.



Уг “Хүүхэд асран хүмүүжүүлж буй бага орлоготой өрхөд олгох амьжиргааг дэмжих тусгай тэтгэмж”-ийг далимдуулсан **“Дансаар шилжүүлэх залилан” болон “хувийн нууц мэдээлэл”** алдагдахаас болгоомжилно уу.

Гэр болон ажил дээр захиргаа, халамжийн газрын ажилтаны дүр эсгэсэн сэжигтэй дуудлага болон шуудан ирвэл оршин суух газрын захиргаа, ойрын цагдаагийн газар эсвэл цагдаагийн тусгай дуудлагын утсанд (#9110) мэдэгдэнэ үү.